



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 08 өдөр

Дугаар A/254

Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/а/, 29. 2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.8 дахь заалт, Сангийн сайдын тушаалаар батлагдсан нөөц хөрөнгө гаргах тухай журмын 2.3.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Монгол улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээн Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт дахь Зэвсэгт хүчний нэгдсэн сургалтын төвд 2017 оны 05 дугаар сарын 10-наас 20-ны өдрүүдэд явагдах тэмцээнд манай аймагт байрлах Зэвсэгт хүчний 110, 186, 234 дүгээр ангиудын байнгын болон хугацаат цэргийн алба хаагчдын бүрэлдэхүүн оролцох тул дээрхи ангиудад шаардлагатай шатахууны зардалд дэмжлэг үзүүлж зохион байгуулахыг Цэргийн штаб /Хурандаа н.Батсуурьт/-т даалгасугай.

Хоёр.Тэмцээнд оролцох шатахуунд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

Гурав.Монгол улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд шаардагдах 3447000 /Гурван сая дөрвөн зуун дөчин долоон мянган / төгрөгийг Засаг даргын нөөц зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэгт/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 8 -ны өдрийн
А/254... дугаар захирамжийн хавсралт

ЗАРДАЛ ТӨСВИЙН ТООЦОО

д/д	Албан байгууллага	Шаардагдах шатахуун /литр/	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Зэвсэгт хүчний 110 дугаар анги	Дизель түлш 200 литр	1790	358000
		Автобензин 300 литр	1550	465000
				823000
2	Зэвсэгт хүчний 186 дугаар анги	Дизель түлш 400 литр	1790	716000
		Автобензин 700 литр	1550	1085000
				1801000
3	Зэвсэгт хүчний 234 дүгээр анги	Дизель түлш 200 литр	1790	358000
		Автобензин 300 литр	1550	465000
				823000
	Нийт			3447000

00